



9-11 нас

Хүүхдэд зориулсан зурган библи

Бүтээлч ном

Шинэ гэрээ
2



Хүүхдэд зориулсан зурган библи

Бүтээлч ном **Шинэ гэрээ 2**

9-11 нас

Эмхэтгэсэн

|  kidsworship

 Selah
Ministry of Christian Publishing

Орчуулагч | N.Soninbayar График дизайнер | Jeewon Park, Julio Blas Засварласан | N.Soninbayar

Энэ номыг зохиогчын зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлахыг хориглоно.

ГАРЧИГ



1. Гүйлгачин Лазар	6
2. Закхай	10
3. Иерусалимд ирсэн нь	14
4. Бэлэвсэн эмэгтэйн хоёр денар	17
5. Сүүлчийн зоог	20
6. Загалмай	23
7. Амилалт	28
8. Анхны чуулган	31
9. Петр	36
10. Стефаны үхэл	40
11. Элч Паул	43


Миний ахиц дэвшил




Тухайн библийн түүхийг үзэж дуусгасны дараа библийг өнгөөр ялган будаарай.



QR кодыг
уншуулан дараах
видеог үзээрэй.





Түүх 1 : Гүйлгачин Лазар

Библийн эшлэл
[Лук16:25]

Абрахам “Хүү минь, чи амьдралынхаа туршид сайн сайхан зүйлээ хүлээн авахад Лазар ч тэрчлэн муугаа авсныг чи санаач. Харин одоо тэр энд тайтгарч, чи тэнд зовж байна.”

Эрт цагт маш баян нэгэн амьдардаг байжээ. Тэрээр гоё хээнцэр гэртээ элдэв үнэтэй хувцас өмсөн амьдардаг байжээ. Мөн өдөр бүр дээд зэрэглэлийн хоол идэж уун хөгжилдөн цэнгэж тансагладаг байв. Ингэхдээ тэрээр өдөр бүр найзуудаа дуудан найр наадам хийн хөгжилддөг байлаа. Баян эр Бурханд итгэдэггүй зөвхөн өөрхийнхөө төлөө амьдардаг байв. Баяны гэрийн үүдэнд Лазар хэмээх юу ч үгүй гүйлгачин амьдарч байлаа. Тэр баяны хашааны үүдэнд хэвтэж биен дээр нь гарсан яр шархнаас болж зовдог байлаа. Тэр сольж өмсөх хувцасгүй учир бохир заваан дээрээс нь баяны ширээнээс унах хоолны үлдэгдэл байна уу үгүй юу гэж ажиглан харж түүж иддэг байв. Харин нэгэн өдөр тэр Бурханд итгэж, итгэлийн хүн болдог. Гүйлгачин Лазар нас барав. Лазарыг Бурханы илгээсэн зарц нар дагуулан тэнгэрийн улсад аваачив. Тэр газарт Лазар Бурханд хамгийн сайн итгэдэг байсан өвөг дээдэс Абрахамтай хамт байлаа. Төд удалгүй баян хүн ч үхэв. Баян хүн тамд унан, маш аймшигтай зовлон эдлэв. Тамын гал хэзээ ч унтардаггүй бас маш халуун. Баян маш хэцүүгээр зовж шаналан ам нь цангаж үс хайв. Харин тэр газарт уух үс байсангүй. Зовон шаналж байсан баян санаандгүй дээшээ хартал тэнгэрийн улс харагдав. “Хөөх юу болох нь энэ вэ? Гүйлгачин Лазар бидний өвөг дээдэс Абрахамын өвөрт тэврүүлсэн байх чинь” гээд баян, гүйлгачин Лазарт маш ихээр атаархав. Тэгээд өвөг дээдэс болох Абрахам руу хашгирч гарав. “Абрахам аа, амь авраач би гал дунд тарчлан зовж байна. Маш халуун байна. Та ядаж Лазараар ч болов дамжуулаад дусал үс явуулж хэлийг минь дэвтээгээч” хэмээн хашгирав. Абрахам түүнд хандан, “Баян хүн гуай, Лазар чам руу явж чадахгүй. Чи дэлхий дээр амьдарч байхдаа сайн зүйлийг л харж өөрийнхөө төлөө л аз жаргалтай амьдарсан. Чи одоо үүнийхээ төлөө тамын шийтгэлийг авч байна. Тэгээд ч чи бидний хооронд маш том ангал байгаа учир бид тийшээ очиж чадахгүй. Мөн тэр газраас нааш нь ирж ч чадахгүй.” Баян амьд байхдаа гүйлгачин Лазарт нэг ч удаа тусалж байгаагүй. Хөршөө хайрлахыг мэддэггүй хүн байв. Энэ баян хүн шиг Бурханыг хайрлаж мэддэггүй хүн Бурханы ард түмэн болж чадахгүй. Бурханыг хайрлаж, хөршөө өөрийн бие мэт хайрла гэж Есүс бидэнд хэлсэн байдаг.

Бүтээлч байцгаая 1. Доорх зургийг хайчилж аваад өнөөдрийн сурсан түүхийн дагуу дарааллуулан наагаарай.

1

2

3

4

5

6



а. 1) Бурханд итгэдэггүй баян хүний амьдрал ямар байсан бэ?

б. Бурханд итгэдэг Лазарын амьдрал ямар байсан бэ?

с. Лук 16:19-31 эшлэлийг уншаад хариулаарай. Баян хүн болон гүйлгачин Лазар хоёр үхсэний дараа хаашаа явсан бэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад, цээжлээрэй. (Лук16:25)

Абрахам “Хүү минь, чи амьдралынхаа туршид сайн сайхан зүйлээ хүлээн авахад Лазар ч тэрчлэн муугаа авсныг чи санаач. Харин одоо тэр энд тайтгарч, чи тэнд зовж байна.”